



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/72

Мандалговь

“Сургуулийн орчны эрүүл ахуй,
хоол үйлдвэрлэл-Өсвөр насны хүүхдийн
эрүүл мэнд-хамтын ажиллагаа” сургалт зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын суралцагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, сургалтын орчны эрүүл ахуйг сайжруулах, өсвөр насны хүүхдийн эрх, хамгааллын талаар мэргэжлийн албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор “Сургуулийн орчны эрүүл ахуй, хоол үйлдвэрлэл-Өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд-хамтын ажиллагаа” сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 380000 (Гурван зуун наян мянга) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Сургалтыг чанартай зохион байгуулахыг нийт гишүүдэд, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190195